**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 24 өдөр Дугаар А/437 Мандалговь

Аймгийн “Хүндэт иргэн” цол тэмдэг
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30.1.17, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг Даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6, Засаг даргын 2017 оны А/251 дугаар “Шагналын журам батлах тухай” захирамжийн нэг дүгээр хавсралтаар батлагдсан Дундговь аймгийн “Засаг даргын шагнал олгох журам”-ын 3.1, 4.1, 5.1 дэх заалт, аймгийн засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 16 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хөгжил дэвшилд оюун ухаан, авьяас чадвар, бие сэтгэлээ зориулан ажиллаж байгаа Цэнмаагийн Тогтохбаатар, Ёндонжамцын Максим, Сандагийн Од-Эрдэнэ, Бямбаагийн Лхагвамандал, Баасанжавын Өлзийхишиг нарыг аймгийн “Хүндэт иргэн” цол тэмдгээр шагнасугай.

2. Шагналд зарцуулах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шагналд зарцуулах 1.275.000 (Нэг сая хоёр зуун далан таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

431210635

Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны
11 дугаар сарын 24-ны өдрийн А/432 дугаар
захирамжийн хавсралт

# АЙМГИЙН "ХҮНДЭТ ИРГЭН" ЦОЛ ТЭМДГЭЭР ШАГНАГДСАН АХМАДЫН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Аймгийн хүндэт иргэн цол хүртэгсэд | Урамшуулал | Өргөнмжлөл үнэ | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Ц.Тогтохбаатар | 200.000 | 55.000 | 255.000 |
| 2 | Ё.Максим | 200.000 | 55.000 | 255.000 |
| 3 | С.Од-Эрдэнэ | 200.000 | 55.000 | 255.000 |
| 4 | Б.Лхагвамандал | 200.000 | 55.000 | 255.000 |
| 5 | Б.Өлзийхишиг | 200.000 | 55.000 | 255.000 |
| | Нийт зардал | 1.000.000 | 275.000 | 1.275.000 |